

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

Орхон аймаг


1. Үндсэн үйл ажиллагаа:

Аймгийн Засаг даргын 2025 оны А/17 захирамжаар 12 орон тоотой байгууллагын стратеги төлөвлөгөөний **5 зорилгын** хүрээнд 2026 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг **7 зорилтын** хүрээнд **44 арга хэмжээг** төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

1.1. Байгууллагын “Эрсдэлийн үнэлгээний журам”-ын дагуу 2026 оны Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан **55** байгууллагаас 2026 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар **22** байгууллагын хяналт шалгалт бүрэн дууссан, **7** байгууллагын хяналт шалгалт 10-95%-тай үргэлжилж байна.

Дотоод аудит, хяналт шалгалтын төрөл

Он	ДА, СХШ-ын /төлөвлөгөөт +төлөвлөгөөт бус тоо/	2026.04.29-ний өдрөөр батлагдсан удирдамжийн тоо	Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус	Дотоод аудит	Санхүүгийн хяналт шалгалт
2026	55+2	29	27	2	19	10



2026 оны төлөвлөгөөт хяналт шалгалтын биелэлт **38%-тай** байна. **Тайлбар:** Хяналт, шалгалтын төлөвлөгөөний биелэлтийг өссөн дүнгээр мэдээллэж байгаа болно.

-Шалгалт бүрэн дууссан байгууллагууд:

1. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ
2. Их шүтээн ОНӨААТҮГ
3. Үйлс бадрах ӨЭМТөв
4. Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан
5. 20-р цэцэрлэг
6. 5-р цэцэрлэг

7. 2-р цэцэрлэг
8. 16-р цэцэрлэг
9. Жаргалант сумын хоршоо хөгжүүлэх сан
10. 11-р цэцэрлэг
11. 24-р цэцэрлэг
12. 19-р цэцэрлэг
13. 4-р цэцэрлэг
14. 3-р цэцэрлэг
15. 21-р цэцэрлэг
16. Хотын захирагчийн алба (**төлөвлөгөөт бус**)
17. 10-р цэцэрлэг
18. 4-р сургууль
19. 8-р сургууль
20. “Жаргалант ус дулаан түгээх станц” ОНӨХК
21. Оюу цэцэрлэг
22. Одод цэцэрлэг

Дээрх байгууллагуудын гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт танилцуулж, тогтоосон акт, албан шаардлага, ажил сайжруулах зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд хангуулан ажиллаж байна.

-Шалгалт бүрэн дуусаагүй байгууллагууд:

1. Баян-Өндөр сумын ОНХСан
2. 20-р сургууль
3. Гаалийн газар
4. 17-р цэцэрлэг
5. Татварын газар
6. 1-р сургууль
7. Худалдан авах ажиллагааны газар

Дээрх байгууллагуудын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж байна.

1.2. Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 85 байгууллагын 2026 оны 1 дүгээр улирлын **"Шилэн дансны тухай хууль"**-ийн хэрэгжилтэд дотоод аудитыг гүйцэтгэж байна. Гүйцэтгэлийн явц 30%-тай байна.

1.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй /ХАБЭА/-н дэлхийн өдрийг угтан манай улс жил бүрийн 4-р сард **"Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян"** зарлан ХАБЭА-н хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон арга хэмжээг зохион байгуулдаг. Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар нь Сарын аяны төлөвлөгөөг байгууллагын ХАБЭА хариуцсан ажилтан 7 арга хэмжээг төлөвлөн газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажилласан. **Онцлох ажлаас дурьдвал:**

- Байгууллага **"Эрүүл хамт олон-2026"** уриан дор 11 албан хаагчийг урьдчилан сэргийлэх үзлэгт оношилгоонд хамрууллаа.
- Хотын захирагчийн албатай хамтран "Эрдэнэт хотын 50 жилийн ойн" нэрэмжит захиргааны III байранд үйл ажиллагаа явуулдаг Төрийн **8** байгууллагын **146** албан хаагчдын дундах нөхөрсөг **спортын 3 төрөлт тэмцээнийг** 2026.04.06-2026.04.09-ны хооронд амжилттай зохион байгуулсан.



- “Хамтдаа гүйе-Эрдэнэт” арга хэмжээнд байгууллагын ХАБЭА хариуцсан ажилтан 7 хоног болгоны хагас сайн өдөр зохион байгуулдаг 5 км-ын гүйлтэд 3 удаа оролцсон.



1.4. Байгууллагын эцэг эхийн зөвлөлийн 2026 оны үйл ажиллагаанд тусгагдсан дараах ажлууд энэ сард зохион байгуулагдлаа. Үүнд:

- **2026.04.03-ны өдөр "Зүрх сэтгэлийн карьер"** сургалтын төвийн мэргэшлийн сургагч багштай хамтран **"Эерэг хоногшлыг бүтээх"** сэдэвт сургалтад албан хаагчдын 11-18 насны 10 хүүхдэд зохион байгуулсан.



1.5. Газрын 11 албан хаагч 2026.04.27-ны өдөр **"ХОТЫН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНД НЭГДЭЖ"** байгууллагын хуваарьт 50м талбай хог хаягдлыг цэвэрлэн, өнгө үзэмжийг сайжруулах ажилд идэвхтэй оролцсон.



1.6. Шилэн ажиллагааны www.shilen.gov.mn сайтад 2026 оны I улирлын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нээлттэй мэдээллийг 5 бүлгийн 87 талбарт байршуулж 2026.03.09-ны өдөр тайланг илгээсэн. Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээгээр **99.88%-тай** үнэлэгдсэн.

Орхон аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, дотоод аудитын алба | П.ДАВААЖАРГАЛ | dawaajargal819@gmail.com

Нүүр / Индексийн тайлан

Индексийн тайлан

Тайлант үе: 2026 оны 1-р улирлын тайлан (2026-1) | Төлөв: Сонгох | Хайх | Цэвэрлэх

Нийт: 10

#	Тайлант үе	Хувилбар	Төлөв	Төлөвийн огноо	Илгээсэн хэрэглэгч	Баталгаажсан үнэлгээний хувь	Баталсан мэргэжилтэн	Үйлдэл
1	2026 оны 1 улирал	1	Баталгаажсан	2026-03-31	dawaajargal819@gmail.com	99.88%	Д.БОЛОРЦЭЦЭГ	

2. СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨН:

Төрийн албаны зөвлөлөөс 4 дүгээр сараас эхлэн 7:4:10 сургалтыг зохион байгуулж эхэлсэн. Энэ сарын 4 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 32 албан хаагч хамрагдсан. Үүнд:

- 2026.04.02-ны өдөр “Төрийн албан хаагчийн чадамжийн хүрээний ерөнхий мэдээлэл”, “Төрийн захиргааны албан хаагчдын чадамжийн оношилгоо, судалгааны дүн”-ийн танилцуулга мэдээлэл” сэдэвт сургалт
- 2026.04.09-ний өдөр “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын танилцуулга, мэдээлэл
- 2026.04.16-ны өдөр “МУ-ын Засгийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, их өгөгдөл суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын системийн тухай” сэдэвт мэдээлэл
- 2026.04.23-ны өдөр “Сөрөн тэсвэрлэх чадвар” сэдэв сургалт

Байгууллагын 2026 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан төлөвлөгөөт дараах сургалтыг зохион байгууллаа. Үүнд:


- 2026.04.02-ний өдөр Нууцын ажилтан “Тагнуулын газар”-тай хамтран “Төрийн болон албаны нууцын тухай хууль” сэдэвт сургалтад 11 албан хаагч
- 2026.04.16-ны өдөр байгууллагын Ёс зүйн дэд хороо “Насан туршийн суралцахуй төвтэй хамтран “Монголын уламжлалт анагаах ухааны 4 улирлын идээ ундаа, явдал мөр”, “Асуудлыг бүтээлчээр шийвэрлэх арга зам” сэдэвт сургалтад 10 албан хаагч



- 2026.04.16-ны өдөр байгууллагын Ёс зүйн дэд хороо “Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар”-тай хамтран “Харилцааны ур чадвар ба манлайлал” сэдэвт сургалтад 11 албан хаагч



- 2026.04.21-2026.04.22-ны өдрүүдэд Улаанбаатар хотод "Ворлд стандарт консалтинг академи" ХХК-тай гэрээ байгуулан “Процесс менежмент”, “Эрсдэлийн үнэлгээ” зэрэг сэдэвт сургалтад байгууллагын Чанарын менежментийн баг, Эрсдэлийн баг, Чанарын дотоод аудитор ажлын хэсэгт ажилладаг 6 албан хаагчийг хамрууллаа.



- 2026.04.28-ны өдөр "Ворлд стандарт консалтинг академи" ХХК-тай хамтран “AI training хиймэл оюун ухааныг дотоод аудитад ашиглах нь” сэдэвт дотоод сургалтыг зохион байгууллаа.



ЗӨВЛӨГӨӨН: 2025.04.29-ний өдөр Эрдэнэт хотын 50 жилийн ойг тохиолдуулан Монголын Хуульчдын холбоо, Орхон аймгийн ГХУСАЗСЗ, Өмгөөлөгчдийн зөвлөл хамтран зохион байгуулсан “Хуульчдын нийгэмд гүйцэтгэх үүрэг” форумд Газрын дарга Д.Сайзмаа оролцсон.



- 3. Үүрэг даалгавар:** 4 дүгээр сард Засаг даргын өргөтгөсөн шуурхайгаас **7 үүрэг даалгавар** ирснийг хэрэгжилтийг ханган ажилласан. Үүрэг даалгаврын биелэлтийг тогтоосон хугацаанд и-оффис системд хааж, биелэлтийн тайланг аймгийн ХШҮХ-т тухай бүр хүргүүлсэн.

5 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АЖЛУУД:

- Төлөвлөгөөт хяналт шалгалтууд хуваарийн дагуу явагдана.
- Байгууллагын төлөвлөгөөт дотоод сургалтууд тогтмол зохион байгуулагдана.
- Эрдэнэт хот байгуулагдсаны 50 жилийн ойн арга хэмжээг угтан хийх ажлуудыг төлөвлөгөөний дагуу хийж дуусгана.
- Цаг үеийн болон төлөвлөгөөт бус байгууллагад холбогдох арга хэмжээнд тогтмол идэвхтэй оролцоно.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР